

БАТЛАВ.

ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮДЭГЧ АГЕНТЛАГ
ОЙН ГАЗРЫН ДАРГА
Б.ОЮУНСАНАА

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

ОЙЖУУЛАЛТ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ОЙН ХӨРСӨН БҮРХЭВЧИЙН ШАТАХ МАТЕРИАЛЫН БҮРЭЛДЭХҮҮН, НӨӨЦИЙН СУДАЛГАА ХИЙХ

ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР:

Ойн түймрийн муж:

1. Хэнтий

СУДАЛГААНЫ ҮЕ ШАТ:

- Судалгааны аргазүй боловруулах

-Хээрийн хэмжилт судалгаа

-Материал боловсруулалт

БЭЛТГЭЛ АЖИЛ

- Судалгаанд хэрэглэгдэх багаж тоног төхөөрөмжийн техникийн паспорт, техникийн үзүүлэлтүүд, баталгаажуулалтын баримт бичгийг хавсарган ирүүлэх;
- Ойн хөрсөн бүрхэвчийн шатах материалын бүрэлдэхүүн болон нөөцийг илрүүлэх судалгааны ажлын сэдэвчилсэн аргзүй ирүүлэх;
- Тухайн бүс нутгуудын түймрийн эрсдэлийн зураг (Масш.1:500000) дээр судалгааны ажил явуулах талбайг тэмдэглэх;
- Судалгааны аргазүй болон технологийн карт боловсруулахад ашиглаж ишлэл авсан гадаад, дотоодын судлаачдын бүтээлийн жагсаалтыг ирүүлэх;
- Судалгааны багын гишүүд нь байгалийн түймрийн болон ойн нөөц, баялгийн чиглэлээр судалгаа хийж байсан болон хээрийн, материал боловсруулалтын ажлын дадлага, туршлагтайг нотолсон мэдээлэл ирүүлэх;
- Судалгаа явуулах бүс нутагт гарсан ой, хээрийн түймрийн олон жилийн мэдээлэл, байгалийн түймрийн аюул болон эрсдэлийн судалгаа, зураглал болон бусад холбогдох мэдээлэлтэй танилцсан байдлын бэлтгэл хангах;

**ШАТАХ
МАТЕРИАЛЫН
СУДАЛГААНЫ АЖИЛ**

Доор дурдсан техникийн ерөнхий шаардлагыг хангасан байна. Үүнд:

| д/д | Техникийн шаардлага | Нийлүүлэгчийн санал |
|-----|--|---------------------|
| 1. | Хэнтийн уулын тайгархаг бүслүүрийн ойг төлөөлөх Мөнгөнморьт орчмын ойн бүс нутаг болон Зүүн хойд Хангайн уулын тайгархаг бүслүүрийн нарсан ойг төлөөлөх Хялганат орчмын янз бүрийн ойн хэв шинж бүхий ойг сонгож, сорьц талбай байгуулах | |
| 2. | Ажиглалтын хэсгүүдэд 0.15-0.50 га хэмжээнд хэлбэлзэх сорьц талбай байгуулна. | |
| 3. | Сорьц талбайд ойн бичиглэл үйлдэх | |
| 4. | Сорьц талбай тус бүрд 20х25см хэмжээ бүхий 5 ширхэг тооцоот талбай байгуулах. Тооцоот талбай өөр хооронд 3м зайтай. | |
| 5. | Тооцоот талбайн хөрсөн бүрхэвчийн шатах материалыг 3 бүлэгт ялгаж дээж цуглуулна. Үүнд: 1.Ойн унаш, 2.Өвслөг ургамал, 3.Сөөг ургамал | |
| 6. | Бүлэг бүрээр цуглуулсан дээж материалын жинг тодорхойлж, материал боловсруулалтын ажлыг хийнэ(аргазүйн дагуу). | |
| 7. | Ойн хөрсөн бүрхэвчийн шатах материалын нөөц тогтоох тоон материал бүрдэнэ. | |
| 8. | Хээрийн судалгааны ажил гүйцэтгэх хугацаа: 2024.05.20 – 2024.08.20 | |

Зөрчил,гологдол арилгах

Судалгааны ажлын аргазүй, материал боловсруулалт, дээж бүрдүүлэлт, хэмжилтэд гарсан зөрчил дутагдлыг гүйцэтгэгч тал залруулах үүрэг хүлээх ба энэ талаар тендерт оролцогч захиалагчид албан бичгээр тодорхойлолт гаргаж өгнө.

Судалгааны ажлын үр дүн нь захиалагчаас ирүүлсэн ажлын даалгаврын шаардлагыг хангаагүй тохиолдолд гүйцэтгэгч судалгааны ажлыг өөрийн хөрөнгөөр давтан хийж ажил хүлээн авах комисст хүлээлгэн өгнө.

Тайлан боловсруулах

Ойн хөрсөн бүрхэвчийн шатах материалын бүрэлдэхүүн, нөөцийн судалгааны ажлын тайланг 2 хувь боловсруулж захиалагчид ирүүлнэ. Тайлан доор дурдсан бүрдэл хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

а/ Судалгаа хийсэн нутаг тус бүрээр ойн хөрсөн бүрхэвчийн шатах материалын бүрэлдэхүүн, нөөцийн судалгааны ажлын тайлан;

б/ Судалгааны ажлын тайланд техникийн ерөнхий шаардлагаар тавигдсан шаардлагуудыг бүрэн хангасан байх;

в/ Ойн хэвшинж бүрийн хөрсөн бүрхэвчийн шатах материалын олон янз байдал болон ойн ерөнхий байдлыг харуулсан фото зураг.

г\ Судалгааны ажлын хүрээнд цуглуулсан нэмэлт мэдээллүүдийг хавсарган ирүүлнэ

д\ Тайланг Ойн газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээлгэн өгнө. Хэрэв тайланд зөрчил гологдол илэрсэн бол түүнийг арилгах үүргийг гүйцэтгэгч хариуцна.

Зөрчил гологдол арилгасан тухай төслийн менежер мэдэгдэл гарган дахин даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээн авсны дараа эцсийн шатны санхүүжилт олгоно.

Зураг боловсруулалтын ажлыг Засгийн газрын 2009 оны 1-р сарын 28-ны өдрийн 25-р тогтоолын дагуу олон улсын WGS-84 солбицлын систем, өндрийн сүлжээний Балтийн тэнгисийн тогтолцоог, том дунд масштабын байр зүйн зураглалд дэлхийн хөндлөн меркаторын UTM (UNIVERSAL TRANSVERS MERCATOR) тусгагийг хэрэглэнэ.

Сорьц талбайд ойн болон геоботаникийн бичиглэл (тухайн ойн ургаж буй газрын нэр, ургах орчин, хэвшинж) үйлдсэн талбайн бүдүүвч зураг, дээж талбайн ойн болон хөрсөн бүрхэвчийн өнгөт зургийг хавсаргасан байна.

Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх

Ойн хөрсөн бүрхэвчийн шатах материалын бүрэлдэхүүн, нөөцийн судалгааны ажлын тайланг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар, Захиргаа, удирдлагын хэлтэс, Ойн нөөцийн хэлтэст тус тус нэг хувийг хүргүүлнэ. Тайланг зөвшөөрөх хугацааг ажлын үе шатны хуваарьт тусгасан болно. Тайланг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газарт нээлттэй хэлэлцэнэ.

Ойн хөрсөн бүрхэвчийн шатах материалын судалгааны явцын тайланг 2024 оны 08 дүгээр сарын 05-ны дотор, эцсийн тайланг 2024 оны 09 дүгээр сарын 20-ны дотор Ойн газарт ирүүлнэ.

ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

| д/д | Ажлын нэр, тодорхойлолт | Тоо, хэмжээ | Нийлүүлэх хуваарь |
|-----|---|--------------|----------------------|
| 1 | Бэлтгэл ажил | - | 2024-06-01-ны дотор |
| 2 | Хэнтий болон Зүүн хойд Хангайн уулын тайгархаг бүслүүрийн янз бүрийн ойн хэв шинж бүхий ойд байнгын ажиглалтын хэсэг сонгож, сорьц талбай байгуулах | - | 2024-07-01-ны дотор |
| 3 | Ажиглалтын хэсгүүдэд 0.15-0.50 га хэмжээнд хэлбэлзэх сорьц талбай байгуулна. | 0.15-0.50 га | 2024-07-10-ний дотор |
| 4 | Сорьц талбайд ойн болон геоботаникийн бичиглэл үйлдэх | - | 2024-07-20-ны дотор |
| 5 | Сорьц талбай тус бүрд 20x25см хэмжээ бүхий 5 ширхэг тооцоот талбай байгуулах. Тооцоот талбай өөр хооронд 3м зайтай. | - | 2024-07-25-ний дотор |
| 6 | Тооцоот талбайн хөрсөн бүрхэвчийн шатах материалыг 3 бүлэгт ялгаж дээж цуглуулна. Үүнд: 1.Ойн унаш, 2.Өвслөг ургамал, 3.Сөөг ургамал | - | 2024-08-20-ны дотор |
| 7 | Ойн хөрсөн бүрхэвчийн шатах материалын нөөц тогтоох тоон материал бүрдэнэ. | - | 2024-08-25-ны дотор |
| 8 | Бүлэг бүрээр цуглуулсан дээж материалын жинг тодорхойлж, материал боловсруулалтын ажлыг хийнэ. (аргазүйн дагуу). | - | 2024.08.25-09.10 |
| 9 | Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх | - | 2024-09-25-ны дотор |